



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 4/12

Мандалговь

“Юу Би Жи” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/73 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сан, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Мал угаалгын суурин ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Юу Би Жи” ХХК-тай 56,974,280 (тавин зургаан сая есөн зуун далан дөрвөн мянга хоёр зуун ная) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу Мал угаалгын суурин ванн шинээр барих ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Юу Би Жи” ХХК-ний захирал (Х.Сонинхүү)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

88113591

ДАРГЫН АЛБАН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210170